



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.07 № ГНАГ-2024/13-ЦТА-НА-34
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн

018020983

тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.


Дүгнэлт

Ардчилсан намын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хүдэр сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (....5..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУИ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ОНОВЧТОЙ БОДЛОГО ОРЛОГОТОЙ ӨРХ

2024 он

ТОВЧ УТГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

ХОЁР. БОЛОВСРОЛ

ГУРАВ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ТАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО, САНХҮҮ, ТАТВАР

ЗУРГАА. ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, ХАА-Н ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

ДОЛОО. ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

НАЙМ. СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР СПОРТ

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД:

- 1.1. Иргэдийн насны бүлэгт тохирсон халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулан өвчлөлтэй иргэдийг эрүүлжүүлэх “Эрүүл-Хүдэрчүүд” арга хэмжээг зохион байгуулна.
- 1.2. Иргэдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах ажил үйлчилгээг сайжруулах, шүд цоорох өвчлөлийг бууруулах зорилгоор шүдний кабинеттай болох, гэрээгээр шүдний эмч ажиллуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3. Эмийн нэр төрөл, чанар, хангалтыг сайжруулах, үнийн тогтвортой байдлыг хангах, ЭМД-ын эмийн хөнгөлөлтийг сурталчилж, хамрах хүрээ, хүртээмжийг сайжруулах талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.4. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5. Сумын хэмжээнд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.
- 1.6. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах дундаж наслалтыг нэмэгдүүлэх хүрээнд эрүүл, аюулгүй ээлттэй орчныг бүрдүүлж, эрүүл амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэн эрт илрүүлэлтийг оновчтой тасралтгүй зохион байгуулж, “80+” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.7. Эмч, сувилагчдыг нарийн мэргэжлээр сургаж, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.

ХОЁР. БОЛОВСРОЛ

- 2.1. Хүүхэд, залуучуудад сум, орон нутгийнхаа түүх, уламжлал, онцлогийг таниулах, судлах, бахархлыг төрүүлэхэд чиглэсэн чиглэсэн богино хугацааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.2. Багш, эмч, төрийн албан хаагчийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, амжилтыг урамшуулж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулах.
- 2.3. Гадаад болон дотоодын их дээд сургууль, коллежид сурч буй оюутны сургалтын төлбөрийг хөнгөлөх, тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэн суманд дутагдалтай байгаа боловсон хүчнийг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудтай идэвхтэй хамтарч ажиллана.
- 2.4. Дутагдалтай байгаа багшийн орон тоог хангах зорилгоор чадвартай багшийг урьж ажиллуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 2.5. Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулж, судалгаа шинжилгээ болон шинэлэг бүтээлийг орон нутагт нэвтрүүлэх шат дараалсан ажил зохион байгуулна.
- 2.6. Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах, цахим хэрэглээг хязгаарлах, донтолтоос урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн өвчлөлийг эрт илрүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.7. Дотуур байрны орчин, хүүхдийн ая тухтай сурч, амьдрах нөхцөлийг сайжруулах төслийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

- 2.8. СӨБ-ын байгууллагын урлаг заалыг тохижуулах тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлого баримтална.

ГУРАВ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 3.1. Өрх бүр үйлдвэрлэгч, өдөр тутмын орлоготой болоход чиглэсэн “Хүдэрийн хөгжил-2035” дунд хугацааны хөтөлбөрийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.2. Гарааны бизнес эрхэлж шинээр ажлын байр бий болгож буй иргэн, ААН-ийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.3. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ний “Төмөртэй” уурхай, Монголын төмөр замын “Төмөртэй” өртөө зэрэг байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.
- 3.5. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчлөх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настны амралт сувиллын газар байгуулах иргэн, ААН-ийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.7. Түүх, соёл, ураг удам мэддэг, зөв хандлагатай иргэнийг төлөвшүүлэх “Аав” төслийг боловсруулан, хэрэгжүүлнэ.
- 3.8. Өрх толгойлсон эцэг, эх, хүүхдээ асарч буй эхчүүдэд зориулсан төсөл хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 4.1. Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоно.
- 4.2. Ашиглалтын лиценз эзэмшиж буй уул уурхайн ашиглалт, нийгмийн хариуцлага тавих хяналтыг өндөржүүлж, орон нутаг дахь үр өгөөжийг дээшлүүлнэ.
- 4.3. Бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал хүргүүлж, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.
- 4.4. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.
- 4.5. Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаатай хамтран орчны бүсийг тогтоох, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.


- 4.6. Сумын төвийн өрх, байгууллага, аж ахуйн нэгжийн дунд “Ногоон өрх-Ногоон байгууллага” аяныг жил бүр зохион байгуулж үр дүнг тооцон ажиллана.
- 4.7. Орон нутгийн иргэдийн амьдралд эергээр нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцэд хөрөнгө оруулах хувийн хэвшлийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 4.8. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг бодлогоор дэмжинэ.
- 4.9. Сумын аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын баримт бичиг буюу “Аялал жуулчлалын хөтөлбөрийг боловсруулан “Гэр амралт” арга хэмжээг зохион байгуулан ажиллана.
- 4.10. Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.

ТАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ИРГЭДИЙН ОРОЛЦОО, САНХҮҮ, ТАТВАР

- 5.1. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.
- 5.2. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.
- 5.3. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 5.4. Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 5.5. Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- 5.6. Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- 5.7. Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 5.8. Татварын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.


ЗУРГАА. ХҮНСНИЙ ЭРҮҮЛ АХУЙ, ХАА-Н ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Орон нутгийн эдийн хөгжилд үр нөлөө үзүүлэх “Хүдэр брэнд”-ийн эко, органик, био, натурал бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд бизнесийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.2. Хүнсний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартыг чанд мөрдүүлж ажиллана.
- 6.3. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор органикаар тариалсан төмс, хүнсний ногоог үйлдвэрлэлд өргөнөөр нэвтрүүлэх, сумын дотоод хэрэгцээг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх.

- 
- 6.4. Хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх бодлого баримтална.
- 6.5. Газар тариалан эрхлэгчдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хөрсний агрохимийн шинжилгээнд тариалангийн талбайгаа хамруулах, хашаажуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.6. Улс болон аймаг, сумдын аюулгүйн фондод өвс, хадлан тэжээл бэлтгэн нийлүүлж буй иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, техникийн шинэчлэл хийх асуудлыг бодлогоор дэмжиж, үйлдвэрлэгчтэй хамтран ажиллана.
- 6.7. Хадлангийн талбайд олон наст ашигт ургамал тариалах, бордох зэргээр га-аас авах ургацыг нэмэгдүүлж буй иргэн, ААН-ийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.8. Овор ихтэй ачаа тээвэрлэх зориулалт бүхий төмөр замын ил гармыг байгуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтарч шийдвэрлэнэ.
- 6.9. Өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлнэ.
- 6.10. Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулах ажлыг зохион байгуулна.
- 6.11. Малчдын малаа маллах дундын бэлчээрийг баталгаажуулж, ашиглалтын хариуцлагыг нэмэгдүүлж, малчдын эрх ашгийг хамгаална.
- 6.12. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор “Мал эмнэлгийн үржил”-ийн нэгж байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.
- 6.13. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 6.14. Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулна.

ДОЛОО. ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 7.1. Шинээр баригдаж буй Соёлын төв, бага сургуулийн барилгын ажлыг цаг хугацаанд нь, чанартай гүйцэтгэхэд иргэд, олон нийттэй хамтарч, хяналт тавина.
- 7.2. Дулаан хангамжийн эх үүсвэр болох уурын зуухыг шинэчлэн, гэр хорооллыг инженерийн төвлөрсөн систем холбох ТЭЗҮ-г боловсруулж, шат дараатай хэрэгжүүлнэ.
- 7.3. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөөг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллана.
- 7.4. Сумын төвийн бетонон замыг асфальт болгон сайжруулж, үлдсэн хорооллын замыг хайрган хучилттай болгох ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх санал хүргүүлж, хэрэгжүүлэх бодлого баримтална.

- 
- 7.5. Сумын төвийн инженерийн шугам сүлжээний санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх санал хүргүүлж, шинэчилнэ.
- 7.6. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх далан шуудуу барина.
- 7.7. Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулах, гудамжны гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, айл өрхийг эко оо-той болгох ажлыг эхлүүлнэ.
- 7.8. Хүн амыг эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн ундны цэвэр усаар хангах дэд бүтцийг сайжруулна.
- 7.9. Хүдэрийн адаг, Уялга, Хөцөө чиглэлд үүрэн телефоны сүлжээ байгуулах асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 7.10. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх тоглоомын талбайг шинэчилнэ.

НАЙМ. СОЁЛ УРЛАГ, БИЕИЙН ТАМИР СПОРТ

- 8.1. Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.
- 8.2. Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 8.3. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Номтой нөхөрлөө” аяныг ижил бүр зохион байгуулан үр дүнг тооцон ажиллана.
- 8.4. Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.
- 8.5. Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 8.6. Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 8.7. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор дугуйлан секцийг үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.
- 8.8. Спортын арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.

ХҮДЭР СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО